

НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТОБААЗ

ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ

/1974-2012 он/

АРХИВЫН ШИФР

Хөмрөгийн дугаар	221
Дансний дугаар	1
Байнга хадгалах баримтын тоо	68 ХН
Баримтын оны хязгаар	1992-2004 он

БАЙГУУЛЛАГЫН НЭРИЙН ӨӨРЧЛӨЛТ

Д/д	Дээд газрын шийдвэр	Нэрийн өөрчлөлт
1	1973 он	Төрийн үйлчилгээний аж ахуйн харьяа Хөнгөн тэрэгний хэсэг
2	1974 он	Улаанбаатар хотын АДХГЗ-ны автограш
3	УБ хотын АДХГ-ны 1990 оны 104 дүгээр тогтоол	АХГЗ-ны Нийтийн аж ахуйн үйлчилгээний автобааз
4	УБ хотын АДХГ-ны 1992 оны 23 дугаар тогтоол	Улаанбаатар хотын АДХГЗ-ны Авто бааз
5	1994.01.17	НЗДТГ-ын Авто бааз /НӨУҮГ/
6	2007.07.16	Нийслэлийн Төр захиргааны авто бааз /ОНӨУҮГ/

НЭГ. ХӨМРӨГ ҮҮСГЭГЧИЙН ТҮҮХ

Улаанбаатар хотын АДХГЗ-ны 1974 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 08 дугаар тогтоолоор Хотын АДХГЗ-ны шууд харъяа газар, хэлтсүүдийн жижүүр, дуудлага үйлчилгээний авто машиныг нэгтгэн Сангийн Яамнаас баталсан төсвийн дагуу хотын захиргааны харъяанд хөнгөн тэрэгний гражийн зориулалтаар анх байгуулагдсан байна.

1992 онд АДХГЗ-ны 78 дугаар тогтоолоор 46 автомашин хөдлөх бүрэлдэхүүнтэйгээр Улаанбаатар хотын АДХГЗ-ны Автобааз нэртэй Улаанбаатар хотын хурлын байгууллагууд болон төр захиргааны газар, удирдах газруудад автомашинаар үйлчлэх, үйлчилгээний ажлыг БНМАУ-ын төрийн өмчид тулгуурлан явуулах улсын үйлдвэрийн газар /УҮГ/ болон өргөжиж дүрмэнд заасны дагуу үйлчилгээ эрхэлж, орлогоороо зарлагаа нөхөх, аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллахаар байгуулагдсан байна.

1994 оноос Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын авто бааз, 2007 оны 07 дугаар сараас Нийслэлийн төр захиргааны авто бааз нэртэйгээр Нийслэлийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газар болон нэр нь өөрчлөгдөж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагууд, Захирагчийн ажлын албаны харьяа газрууд болон дүүрэг, байгууллагуудад автомашинаар үйлчлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Авто бааз нь НИТХ, НЗДТГ, НЗД-ын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагууд, ЗАА-ны харьяа газрууд болон дүүрэг, байгууллагуудад автомашинаар үйлчлэн төрийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2003 оны 49 дүгээр захирамжийн дагуу Нийслэл, дүүргүүдийн Мэргэжлийн хяналтын албадаас төвлөрүүлсэн 8 автомашиныг хүлээн авч, засвар үйлчилгээг хийж 6 автомашиныг ажилд оруулан, цаашид ашиглагдахгүй болсон 2 автомашиныг холбогдох материалыг бүрдүүлж Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дуудлага худалдаагаар оруулж шийдвэрлэсэн.

2003 оны 07 дугаар сарын 23-нд авто баазын дарга Чадраабалын Төрбат өөр ажилд шилжиж, авто баазын даргаар Цэрэнбатын Батхуяг томилогдож, одоог хүртэл ажиллаж байна.

Авто бааз нь 2003 оны 3 дугаар улирлаас парк шинэчлэлтийг хийж Нийслэлийн Засаг даргын 326 дугаар захирамж / Авто баазын талаар авах зарим арга хэмжээ/- ийн дагуу шинээр “Даймлер-Бенз-С200К”, “Дэү-Магнус” суудлын автомашин тус бүр нэгийг, “Ниссан Саппоро” жип автомашинуудыг балансаас балансад шилжүүлэн авч, “Самсунг Мастер 551-S” маркийн иж бүрэн компьютер, ширээ, сандал, сейф, шкаф зэрэг эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авч, санхүүгийн ажилд хэрэглэж ажилласан байна.

Нийслэлийн Засаг даргын 2007 оны 329 дугаар захирамжаар байгууллагын нэр өөрчлөгдөж Нийслэлийн төр захиргааны авто бааз болсонтой холбогдуулан, авто бааз УҮГ-ын дүрмийг шинэчлэн боловсруулан, баталгаажуулж, тамга тэмдэг, гэрчилгээ, хэвлэмэл хуудас, гадаах хаягийг шинээр өөрчлөн ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2009 оны 115 дугаар захирамжаар Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын бүтэц орон тоог шинэчилсэнтэй холбогдуулан авто баазын бүтэц орон тоог 69 хүртэл байхаар баталсны дагуу ажилласан.

Монгол улсын Засгийн газрын тогтоолоор 2010 оныг " Үйлдвэржилт, бүтээн байгуулалтыг дэмжих жил" болгосны хүрээнд дараахи ажлуудыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

1. Авто баазын 1 дүгээр паркийн гараашийн шал, ханыг бүрэн хэмжээгээр шинэчлэн засварлаж, авто тээврийн стандартын дагуу болгож, ус зайлуулагч хоолой буюу трапийг шинээр хийж, автомашинуудын байрлал, зогсоолын зурвас хийж, эиэ ажилд 25,6 сая төгрөгийг зарцуулсан.

2. Авто баазын 2 дугаар парк буюу /УБ Бизнес хөгжлийн төвийн доод/ гараашийн диспетчерийн өрөөний хажуугийн сул өрөөг жолооч нарын амралтын өрөө болгож, бүрэн тохижуулж, 3 дугаар парк буюу Хангарьд ордны гараашийн диспетчерийн өрөөнд халаалт /пар/ тавьж, жолооч нарын өрөөг засварлаж, шатар, даам, телевизийн кабелийн суваг тавьж, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд анхаарал тавьж ажиллалаа.

3. Монгол улсад Авто тээврийн байгууллага үүсч хөгжсөний 85 жилийн ой угтсан "Соёлтой үйлчилгээ" нэг сарын аяныг 1, 2, 3 дугаар паркуудын дунд зохион байгуулж, ажил үйлчилгээний соёл, чанар, сахилга, дэг журам, спортын тэмцээнүүдээр нийт ажиллагсдыг хамруулан өрсөлдүүлж, дүгнэн байр эзлүүлээ.

Үүнд:

1 дүгээр байрт: 2-р парк буюу Бизнес хөгжлийн төвийн баг Шилжин явах цом, Өргөмжлөл, мөнгөн шагнал

2 дугаар байрт Захиргаа, санхүү аж ахуйн баг Өргөмжлөл, мөнгөн шагнал

3 дугаар байрт 1 дүгээр парк буюу Төв баазын баг Өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнагдсан байна.

2010 оны Авто техникийн улсын үзлэгт бэлтгэн төлөвлөсөн ажлуудыг хийж, автомашины оношлогоо, шилжилт хөдөлгөөн, үзлэгт шаардлагатай бүх сэлбэг хэрэгсэл, тос тослох материалыг бэлтгэж, автомашинуудад бүрэн засвар үйлчилгээг графикайн дагуу хийж парк ашиглалтыг 73,5-75,5 хувьтай ажиллуулж 2010-2011 оны өвөлжилтийн бэлтгэл ажил, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, 1, 2, 3 дугаар паркуудын дулаалга, галын бэлтгэл ажлуудыг тус тус ханган ажиллалаа.

Бүтээн байгуулалтын жилд төв паркийн гараашийн шал, ханыг бүрэн хэмжээгээр авто тээврийн стандартын дагуу шинэчлэн засварлаж, хүлээн авсан.

Монгол улсын Засгийн газрын тогтоолоор 2012 оныг "Иргэдийн оролцоо- Өрхийн хөгжлийг дэмжих жил" болгосны хүрээнд дараахи ажлуудыг зохион байгуулсан.

1/ Өрхийн хөгжлийг дэмжих зорилгоор ажилтан, албан хаагчдын гэр бүлийн дунд 2012 оны 02 дугаар сард өрхийн орлого, ахуйн нөхцлийн талаарх "Өрхийн судалгаа"-г явуулж судалгаанд нийт 70 ажилтан, албан хаагчид хамрагдаж "Өрхийн судалгаа"-ний дагуу 0-16 насны 76 хүүхдүүдэд байгууллагын зүгээс нийт 760000 төгрөгийн хүүхдийн баярын бэлэг, НЗД бөгөөд УБ хотын захирагчийн нэрэмжит шинэ жилийн баярын бэлгийг 0-10 насны 50 хүүхдүүдэд олгож ажиллалаа.

2/ Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж өөрийн гэр оронгүй байсан нэг манаачид 5 ханатай гэр олгож, Сонгинохайрхан дүүргийн Баруун салааны нутаг дэвсгэрт 51 айлын зуслангийн газрын асуудлыг шийдвэрлүүлж ажилтан албан хаагчдад "Газар эзэмших гэрчилгээ"-г гардуулж өөрсдийн эзэмшилд олгосон.

Мөн НИТХ-ын 2012 оны 2/08 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх тухай Авто баазын даргын 2012 оны А/95 дугаар тушаалыг гаргаж, нийслэлийн замын хөдөлгөөний ачааллыг зохицуулах цогц арга хэмжээний ажлуудыг байгууллагын хэмжээнд дүрмээр хүлээсэн үүрэг, төрийн үйлчилгээний стандартын шаардлага, сахилга хариуцлага, үйлчилгээний чанар, соёлыг дээшлүүлэх талаар дэс дараатай ажлуудыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулан ажиллалаа.

НЗД-ын А/532 дугаар захирамжаар нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтнууд 2012 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаатай албан ажилдаа автомашин хэрэглэхгүй болсон, автомашины улсын дугаарт хязгаарлалт хийгдсэнтэй холбогдуулан байгууллагын үйлчилгээний автомашинуудад хуваарилалт хийж, ажилд гарахгүй жолооч нарын хүчээр авто баазын хашааг өндөрлөж, хаалгыг шинээр хийж, гадаа талбайд ус зайлуулагчийг шинээр хийж ажилд орууллаа.

Монгол улсад Авто тээврийн байгууллага үүсч хөгжсөний 87 жилийн ой, Нийслэлийн 373 жилийн ойгоор улсад болон төрийн үйлчилгээ, авто тээврийн салбарт олон жил ажлын өндөр амжилт гарган, үр бүтээлтэй ажиллаж байгаа жолооч, ажилтан, албан хаагчдыг Төр засгийн одон медаль, Нийслэлийн удирдах дээд байгууллагын шагналуудаар шагнаж урамшууллаа. Үүнд :

Төр засгийн дээд шагнал "Алтангадас" одонгоор жолооч Х.Ганболд, "Хөдөлмөрийн хүндэт" медалиар жолооч Э.Энхзаяа, Нийслэлийн "Хүндэт тэмдэг"-ээр жолооч С.Ганбаатар, хүний нөөцийн мэргэжилтэн Ч.Байгаль, нийслэлийн "Тэргүүний ажилтан" цол тэмдгээр жолооч Б.Юра, Ч.Энхсайхан, мэргэжилтэн Ч.Байгаль, НЗД-ын "Жуух бичиг"-ээр жолооч Б.Батбаяр, М.Өлзийбат, Б.Намсрай, Нийслэлийн "Шилдэг залуу" алтан медалиар Х.Баатарчулуун, М.Бямбадорж, Х.Ажирахгүй, Б.Энхбаяр нар, Сүхбаатар дүүргийн "Хүндэт тэмдэг"ээр жолооч О.Нэргүй, НҮГ-ын шагналаар диспетчер З.Батчулуун, жолооч Б.Амарсанаа, НМХГ-ын шагналаар жолооч З.Очирпүрэв, Нийслэлийн Газрын

албаны шагналаар жолооч В.Жанчив болон бусад ажилтан, албан хаагчдыг дүүрэг, харъяа газар, байгууллагын шагналаар шагнагдаж байгууллагын 2012 оны “Хөдөлмөрийн аварга”-аар жолооч С.Ганбаатар шалгарч, аваргын цомоор тус тус шагнасан байна.

ХОЁР. ХӨМРӨГИЙН БАРИМТЫН ТҮҮХ

Төр захиргааны автобааз нь анх 1973 онд байгуулагдсан боловч олон жижиг автограшуудтай зохион байгуулалтын өөрчлөлтөөр салж нийлэн, нэгдэж тусгаарлагдаж явсаар 1973-1992 он хүртэлх хугацааны архивын баримт гэхээр юм үгүй байна.

1996 онд албан ёсны бичиг хэрийг ажилтантай болж 1992-1995 оны баримтуудыг нягтлангаас хүлээж авсан. 1997 онд автобаазын даргын тушаалаар байгууллагын ББНШАЗК-ыг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 1992-1996 оны архивын баримтуудыг жагсаалтаар нь хөмрөгт хүлээн авчээ.

1999 оны 12 дугаар сарын 16-ний хөтөлбөр төлөвлөгөө гарган баримтуудад зааг хийж ҮЖ-аар хугацаа нь дууссан баримтуудыг түүвэрлэн устгах, төрийн архивт шилжүүлэх талаар Нийслэлийн Архивын албатай харилцаж, хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд 2000 оны 03 дугаар сарын 10-ны өдөр ББНШАЗК нь байгууллагын архивын баримтад тооллого хийж, данс бүртгэл, байгууллагын түүхчилсэн лавлахыг шинэчилж илтгэх хуудсаар Төрийн архивт танилцуулсан. Мөн оны 08 дугаар сард байгууллагын “АРХИВЫН ГЭРЧИЛГЭЭ” авсан байна.

Нийслэлийн архивын газрын архивч сэлбэн засагч М.Энхцэцэг нь дээрхи байгууллагын 61 ХН бүхий баримт бичгийг хүлээн авч 2011 оны 04 дүгээр сарын 07-15-ны хооронд ЭШТБ-ийн ажлыг хийж байнга хадгалах 68 ХН бүхий данс бүртгэлийг үйлджээ.

Нийслэлийн төр захиргааны авто баазын даргын 2012 оны А/97 дугаар тушаалаар батлагдсан ББНШКомисс Х.Ажрахгүй /Ерөнхий инженер/, гишүүдэд Я.Эрдэнэцэцэг /Ерөнхий ня-бо/, Х.Аюуш /Ашиглалтын инженер/, Х.Одончимэг /тооцооны ня-бо/, нарийн бичгийн даргаар Ч.Байгаль /хүний, нөөц, архив, бичиг хэргийн эрхлэгч/ нар томилогдож, байгууллагын архивын үйл ажиллагааг МУ-ын “Архивын тухай хууль”, Засгийн газрын 1995 оны 53 дугаар тогтоол, Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалын дагуу “Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөх журам”, байгууллагын “Архивт баримт хүлээн авах журам”-ын дагуу ажилласан.

2012 оны жилийн эцсийн байдлаар нийт хадгаламжийн нэгжийн тоо 359, үүнээс байнга 94, түр хадгалах хн 246, 70 жил хадгалах хн-ийн тоо 19, НШАЗК-ын хурлаар батлагдсан дансны тоо 1, тусгай төрлийн баримт дүрс бичлэгийн СД 2 /хоёр/ ширхэг, гэрэл зургийн цомог 1 /нэг/ ширхэг, түр хугацаатай ашиглуулсан хн-ийн тоо 79, лавлагаа хуулбар 34-ийг олгосон байна.